

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
НИЙГМИЙН САЛБАР НОГООН ХӨГЖИЛ
БОЛОН АГААР, ОРЧНЫ БОХИРДЛЫН
АСУУДАЛ ХАРИУУАН ОРЛОГЧ
Л. ХОСБАЯР

2024 оны 09 сарын 02 ны өдөр

УДИРДАМЖ

Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Ардын жүжигчин
Д.Лувсаншаравын нэрэмжит хүүхдийн найрал дууны 30 дахь удаагийн улсын уралдаант
наадам зохион байгуулах тухай

2024 оны 09 дүгээр сарын 02

Улаанбаатар хот

ҮНДЭСЛЭЛ:

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1.2-т тусгагдсан "Хүмүүнлэг, оюунлаг хотын иргэдийг бэлтгэхэд боловсрол, соёлын байгууллагын хамтын ажиллагааг өрнүүлж, хотын соёлыг төлөвшүүлнэ" зорилт, Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.6-д тусгагдсан "Үндэсний агуулга бүхий бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлж, хотын соёлыг дээдэлсэн иргэнийг төлөвшүүлнэ" зорилтыг тус тус үндэслэв.

ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА:

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн ивээл дор уламжлал болон зохиогддог Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Ардын жүжигчин Дагвын Лувсаншаравын нэрэмжит 30 дахь удаагийн "Хүүхдийн найрал дууны наадам"-ыг Нийслэл Улаанбаатар хот үүсгэн байгуулагдсаны 385 жилийн ойн хүрээнд улсын хэмжээнд зохион байгуулна.

ЗОРИЛГО:

Ерөнхий боловсролын сургуулиудын хөгжмийн хичээлийн сургалтыг чанаржуулж, өсвөр үеийнхэнд урлаг, уран сайхны боловсрол олгох, гоо зүйн хүмүүжлийг төлөвшүүлэх, хүүхэд бүрийн авьяасыг хөгжүүлэх зорилго оршино.

ЗОРИЛТУУД:

1. Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлах ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд, ахлах ангийн сурагчдыг урлагаар дамжуулж хүмүүжүүлэх, гоо зүйн мэдлэг олгох, тэсвэр тэвчээр суулгах, багаар ажиллах чадварт сургах,
2. Сургуулийн нийгмийн ажилтан, хөгжмийн багш нарын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, удирдан зохион байгуулах, хүүхэд хүмүүжүүлэх, гоо зүйн мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх,
3. Соёл, урлагийн мэдлэг боловсрол олгох, соён гэгээрүүлэх, танин мэдэхүйн сургалт нөлөөллийн ажлын үр дүнг нэгтгэх, тайлагнах.

ЗОХИОН БАЙГУУЛАХ ХУГАЦАА:

1. Анхан шатны шалгаруулалт
2024 оны 10 дугаар сарын 09-11-ний өдрүүдэд Нийслэл, аймаг орон нутагт зохион байгуулна.
2. Хоёрдугаар шатны шалгаруулалт
2024 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн 10:00-17:00 цагт Монголын Хүүхдийн ордонд зохион байгуулна.
3. Нэгдсэн гала тоглолт
2024 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 14:00 цагт Нийслэлийн Соёлын төв өргөөнд зохион байгуулна.

ХАМРАХ ХҮРЭЭ:

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот, аймаг орон нутгийн төр болон хувийн хэвшлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, хөгжмийн багш нар оролцоно.

ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Наадмын бэлтгэл ажил

1. Найрал дууны уралдаант наадмын заавал дуулагдах дууны сургалтыг Нийслэлийн ЕБС-ийн хөгжмийн багш нарын дунд 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 13:00-16:00 цагт Монголын Хүүхдийн ордны тоглолтын их танхимд зохион байгуулна.
2. Аймаг, орон нутгаас тус наадамд оролцогч ЕБС-ийн сурагчдын заавал дуулагдах дууны сургалтын бичлэгийг тухайн аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газарт хүргүүлнэ.
3. Наадамд оролцогч хөгжмийн багш нарт заавал дуулагдах дууны сургалтын зааварчилгааг түгээх ажлыг тухайн аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар хариуцна.

АНХАН ШАТНЫ ШАЛГАРУУЛАЛТ

1. Нийслэл Улаанбаатар хотын зохион байгуулалтын хүрээнд:

2024 оны 10 дугаар сарын 09-11-ний өдрүүдэд наадмын шалгаруулалтын хуваарийн дагуу дүүрэг тус бүрд зохион байгуулах бөгөөд Нийслэлийн Соёл, урлагийн газраас томилогдсон шүүгчдийн бүрэлдэхүүн шүүн явуулж, дүүрэг тус бүрээс шилдэг 3 хамтлагийг шалгаруулна.

Нийслэлийн дүүргүүдийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтсийн Соёлын асуудал хариуцсан мэргэжилтнүүд шалгарсан хамтлагуудын мэдүүлэг болон анхан шатны шалгаруулалтын дүнгийн илтгэх хуудсыг 2024 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 16:00 цагт Нийслэлийн Соёл, урлагийн газрын Соёлын үйлдвэрлэл, урлагийн хэлтсийн nsug.ukh22@gmail.com цахим хаягаар хүргүүлнэ. /Урлаг, уран бүтээлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Шашу, холбогдох утас: 95879597/

2. Аймаг, орон нутгийн зохион байгуулалтын хүрээнд:

2024 оны 10 дугаар сарын 09-11-ний өдрүүдэд наадмын шалгаруулалтын хуваарийн дагуу тус аймгийн ЗДТГ-ын Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар зохион байгуулж, аймаг тус бүр нь шилдэг 1 хамтлагийг шалгаруулж тодруулна.

Шалгарсан хамтлагийн илтгэх хуудсыг 2024 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 16:00 цагт Нийслэлийн Соёл, урлагийн газрын Соёлын үйлдвэрлэл, урлагийн хэлтсийн nsug.ukh22@gmail.com цахим хаягаар хүргүүлнэ. /Ахлах мэргэжилтэн Б.Шашу, холбогдох утас: 95879597/

II ШАТНЫ ШАЛГАРУУЛАЛТ

1. Нийслэлийн дүүргүүд болон аймгуудаас шалгарсан шилдэг хамтлагууд, наадмын II шатны шалгаруулалтад оролцоно.

2. Уралдаант наадмын II шат болон хүндэтгэлийн Гала тоглолтод оролцох орон нутгаас ирэх хамтлагуудын нийслэл Улаанбаатар хотод ирэх, буцах тээврийн болон наадамд оролцох өдрүүдийн хоол, ундны зардлыг орон нутаг өөрсдөө хариуцна. Уралдаанд оролцогчдын байрны зардлыг НСУГ, Монголын найрал дууны уран бүтээлчдийн холбоо хариуцна.

3. Уралдаант наадамд оролцогч сурагчдын аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангаж, эцэг эх, асран хамгаалагч харгалзах хүнтэйгээр дэмжин туслах, хамтын ажиллагаатай багийн зохион байгуулалттай ажиллана.

4. II шатны шалгаруулалтыг Монголын хүүхдийн ордонд зохион байгуулна. Уралдаант наадамд оролцох хамтлагууд, өөрсдийн сонгосон бүтээлийн ноотыг шүүгчдийн бүрэлдэхүүнд хэвлэмэл байдлаар ирүүлнэ.

5. II шатны шалгаруулалтад шалгарсан найрал дууны хамтлагууд уралдаант наадмын хүндэтгэлийн Гала тоглолтод оролцох бөгөөд тус тоглолт дээр шалгарсан хамтлагуудын өргөмжлөл, шагнал урамшууллыг гардуулна

УРАЛДААНТ НААДАМД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- Наадамд оролцох хамтлагууд 3 бүтээлээр оролцоно. Үүнд:
 1. Заавал дуулах дуу - МУУГЗ Б.Алтанхуягийн хөгжим, Г.Энхчимэгийн шүлэг "Монгол хүүхэд" дуу
 2. Хөгжмийн хамсраатай найрал дуу
 3. Дан найрал дуу /а капелла/
- Уралдаанд оролцогчдыг дараах үндсэн шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.
 1. Найрал дууны дуугаралт /хөг, үг хэллэг, хүчдэл, нийлэмж/
 2. Хөгжмийн мэдрэмж, утга санааг илэрхийлэх чадвар
 3. Удирдаач багшийн ур чадвар
 4. Бэлтгэл зохион байгуулалт /тайзны соёл, хувцаслалт/
 5. Оролцогчдын тоо 35-60 хүүхэд

УРАЛДААНЫ ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

Тэргүүн байр- 1	Өргөмжлөл	8.000.000 төгрөг
Дэд байр- 1	Өргөмжлөл	6.000.000 төгрөг
Гутгаар байр- 1	Өргөмжлөл	4.000.000 төгрөг
Тусгай байр- 2	Өргөмжлөл	2.000.000 төгрөг
Шилдэг удирдаач багш-1	Өргөмжлөл	1.000.000 төгрөг
Нэрэмжит шагнал-2	Өргөмжлөл	1.000.000 төгрөг
Шилдэг удирдлага-1	Өргөмжлөл	800.000 төгрөг

ХҮРЭХ ҮР ДҮН:

“Хүүхдийн найрал дууны наадам”-ыг анх 1993 оноос Нийслэлийн Соёл, урлагийн газрын санаачлагчаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн ивээл дор зохион байгуулснаар одоог хүртэл тасралтгүй 30 дахь удаагаа зохион байгуулж байна.

Уралдаанд анх нийслэлийн 6 дүүргээс 20 сургууль оролцож байсан бол өдгөө Нийслэлийн 9 дүүргийн 90 гаруй сургуулийн 12,000 сурагчид тогтмол оролцож байна.

Найрал дууны наадам нь ерөнхий боловсролын сургуулийн хөгжмийн хичээлийн сургалтын түвшнийг ахиулж, хөгжмийн багшийн ур чадварыг сорьж байдгаараа нэг талдаа хөгжмийн хичээлийн олимпиад болдог бөгөөд үүний үр дүнд хүүхдүүдийн дуулах чадвар, багийн эв нэгдэл, хариуцлагатай тууштай байх зан чанарт сургах, тэсвэр тэвчээр суулгах давуу талтайгаас гадна багш нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлсэн ач холбогдол бүхий үр өгөөжтэй, улсын хэмжээний наадам болон өргөжиж, амжилттай зохион байгуулагдаж байна.